



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 650

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 1,962,433,000.00 (нэг тэрбум есөн зуун жаран хоёр сая дөрвөн зуун гучин гурван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Б.ГАВАА



0002725

Төрийн өмчийн боллого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн
632 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДСЭНИЙ ХҮРЭЭЛЭНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИДЖҮҮЛЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Шингэний хроматографи масс спектрометрийн аппарат (6530 LC/MS)	3/16/2018	1,326,424,000.00	1	1,326,424,000.00	-	1,326,424,000.00
	Өндөр идэвхит шингэний хроматографийн аппарат (1290 HPLC)	12/28/2017	249,535,000.00	1	249,535,000.00	-	249,535,000.00
2	Хийн хроматографи масс спектрометрийн аппарат (GC/MS /5977 загварын)	12/28/2017	386,474,000.00	1	386,474,000.00	-	386,474,000.00
	Нийт дүн				1,962,433,000.00 (нэг тэрбум есөн зуун жаран хоёр сая дөрвөн зуун гучин мянган төгрөг)		1,962,433,000.00 (нэг тэрбум есөн зуун жаран хоёр сая дөрвөн зуун гучин гурван мянган төгрөг)